



**УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

**Залуучуудын хөгжлийн зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай**

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг дараах 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

- Зөвлөлийн дарга Г.Бат-Өлзий (Их хуур хөгжимчин)
- Дэд дарга Г.Энхбат (Морин хуур хөгжимчин)
- Нарийн бичгийн дарга О.Анар (Бишгүүр хөгжимчин)
- Гишүүд Ц.Энхмаа (Ёочин хөгжимчин)
- Э.Мөнх-Алдар (Бүжигчин)
- Т.Цолмон (Дууны техникч)
- Н.Бямбадорж (Дуучин)

2. Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дүрмийг тус тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсугай.


3. Театрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийн ажлыг идэвхи санаачилгатай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж хариуцлагатай ажиллахыг зөвлөлийн дарга (Г.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер (Л.Одгэрэл)-т даалгасугай.

ДАРГА



Р.МӨНХСАЙХАН



Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын Даргын
2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн
А/25 дугаар тушаалын хавсралт

“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ-ЫН “ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН ДҮРЭМ

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24-ийн 2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн, 5.1.3 дахь хэсэг, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5.2.8 дахь заалт, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”-ийн 2021 оны 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах дүрмийг баталсугай.

Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрэм нь “Улаанбаатар театр” ОНӨТҮГ-ын “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн /цаашид ЗХЗ гэх/ үндсэн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага зохион байгуулалт, хариуцлага тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 ЗХЗ нь тухайн байгууллагын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих үүрэг бүхий сайн дурын үүсгэл санаачлагын үндсэн дээр бүэлдсэн орон тооны бус зөвлөл байна.

1.3 ЗХЗ нь зохион байгуулалт, үйл ажиллагаандаа энэхүү дүрмийг мөрдлөг болгох бөгөөд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөр, холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллана.

Эрхэм зорилго:

Улаанбаатар театрын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, байгууллага хоорондын хамтын ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд энэхүү зөвлөлийн зорилго оршино.

Алсын хараа

Улаанбаатар театрын үндсэн зорилго болох ардын урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний урлагийг орчин цагийн урлагтай хослуулан шинэ уран бүтээл туурвихад тулгамдаж буй асуудлуудад тус театрын залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

Эрх, үүрэг

- “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн гишүүд нь шинэ санаачлага гаргах, тэдгээрийн үр дүнг шаардах эрхтэй;
- “Залуучуудын хөгжлийн зөвлөл” аливаа уулзалт семинар, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах эрхтэй;
- Залуучуудын санаачлага, сайн дурын үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй;
- ЗХЗ-ийн үйл ажиллагаа нь хүний эрх, хууль ёсыг дээдлэнэ
- ЗХЗ нь бусдыг сонсож ялгаварлан гадуурхахгүй байна
- Үйл ажиллагаа ил тод нээлттэй байна
- ЗХЗ-ийн гишүүд тэгш эрхтэй байна
- Эерэг хандлагатай байна
- Шинийг санаачлагч байна
- Идэвхитэй хамтрагч оролцогч байна
- Хариуцлагатай шударга, эх оронч үзэлтэй байна
- Өрсөлдөх чадвараа хөгжүүлнэ